ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг:serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Н.Баттөгөлдөр
Утас: 261628 Цахим хаяг: battuguldur@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бэст фортуна аудит ХХК
Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 324338, 89116465, 98056465
Цахим хаяг: fortune2009audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7-8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........ 10-11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 12-13
2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан ........14
3. Аудитын тайлан........15
3.1 Ерөнхий зүйл........ 15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 15-16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........16
3.4 Материаллаг байдал ........16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........ 16-17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........ 17-18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........18
3.8 Аудитын гол асуудал ........19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........ 19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ 19-20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........20
4. Аудитын илрүүлэлт ........20
4.1 Залруулсан алдаа ........ 20
4.2 Төлбөрийн акт ........ 20-21
4.3 Албан шаардлага ........21
4.4 Зөвлөмж........22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........23-24
Төлбөр барагдуулах тухай ........25-26
Зөрчил арилгах тухай ........27-29

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ХНХЯ | Хөдөлмөр нийгэм хамгааллын яам |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/388

танай ______-ны № ______-т

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОТГОНБАТ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0225 Auditiin 2 Gazar - 43.Docx

001050407

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0225 Auditiin 2 Gazar - 43.Docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **925,767,681.15** | **883,301,115.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | - |
| **33** | **АВЛАГА** | 171,614,443.90 | 121,751,185.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 12,531,473.90 | 2,585,462.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 110,599,934.00 | 93,380,114.00 |
| **335** | **Бусад авлага** | 48,483,036.00 | 25,785,609.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 48,483,036.00 | 25,785,609.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 27,000,000.00 | 27,000,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 27,000,000.00 | 27,000,000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | - | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 727,153,237.25 | 734,549,930.98 |
| **351** | **Түүхий эд материал** | 794,762.00 | 118,554.00 |
| 35130 | Эм боох материал | 794,762.00 | 118,554.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 726,358,475.25 | 734,431,376.98 |
| 35410 | Түлш шатах тослох материал | 1,427,300.00 | 734,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 183,014,215.02 | 195,467,524.38 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,204,500.00 | 5,473,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 39,030,904.90 | 18,848,933.27 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 499,681,555.33 | 513,906,419.33 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **13,784,588,460.01** | **13,362,220,934.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 13,784,588,460.01 | 13,362,220,934.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 13,645,685,807.10 | 13,217,648,181.53 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 13,564,844,979.00 | 13,673,050,108.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,013,627,273.34) | (1,392,288,697.47) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 486,983,476.70 | 486,983,476.70 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (423,558,904.65) | (434,354,068.18) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,760,349,758.06 | 1,774,086,408.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,247,111,762.82) | (1,347,071,741.67) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 708,648,785.40 | 710,532,179.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (541,352,888.06) | (564,901,553.20) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 517,853,609.53 | 517,853,609.53 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (167,343,972.72) | (206,241,539.64) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 138,902,652.91 | 144,572,752.85 |
| 39301 | Програм хангамж | 8,692,044.00 | 8,692,044.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (8,692,044.00) | (8,692,044.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 152,708,200.00 | 159,128,300.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (13,805,547.09) | (14,555,547.15) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **14,710,356,141.16** | **14,245,522,050.36** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **327,228,719.67** | **200,627,608.63** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **327,228,719.67** | **200,627,608.63** |
| **413** | **Өглөг** | 216,040,469.67 | 116,027,608.63 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 67,309,402.67 | 50,961,044.63 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 136,946,860.00 | 55,973,868.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 11,784,207.00 | 9,092,696.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 11,003,861.00 | 8,312,350.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 780,346.00 | 780,346.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | 111,188,250.00 | 84,600,000.00 |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | 111,188,250.00 | 84,600,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **14,383,127,421.49** | **14,044,894,441.73** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 14,383,127,421.49 | 14,044,894,441.73 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,201,162,456.84 | 6,207,582,556.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 6,201,162,456.84 | 6,207,582,556.84 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (3,425,283,801.41) | (3,769,936,881.17) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (2,944,537,009.81) | (3,425,283,801.41) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (480,746,791.60) | (344,653,079.76) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 11,607,248,766.06 | 11,607,248,766.06 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **14,710,356,141.16** | **14,245,522,050.36** |

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,945,367,091.19** | **3,835,888,639.58** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,509,221,391.19** | **1,461,457,239.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,509,221,391.19 | 1,461,457,239.58 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,480,119,502.59 | 1,403,132,938.58 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,311,134,776.00 | 838,006,400.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 168,384,726.59 | 565,126,538.58 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 19,040,000.00 | 58,324,301.00 |
|  | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 10,061,888.60 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,436,145,700.00** | **2,374,431,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,436,145,700.00 | 2,349,181,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,436,145,700.00 | 2,349,181,400.00 |
| 131005 | Нэмэлт  санхүүжилтийн орлого | 00.00 | 25,250,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 25,250,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **4,426,113,882.79** | **4,180,541,719.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,426,113,882.79** | **4,180,541,719.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,320,904,708.93 | 4,085,461,658.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,609,595,788.48 | 1,579,286,874.49 |
| 210101 | Үндсэн цалин | 1,609,487,553.48 | 913,946,314.68 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 00.00 | 516,104,284.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 144,263,775.61 |
| 210105 | Гэрээт ажилтан | 108,235.00 | 4,972,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 198,728,132.00 | 214,888,474.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 137,330,611.00 | 155,617,655.80 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,156,544.00 | 15,869,531.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,626,194.00 | 12,453,704.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,926,645.00 | 2,780,998.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,688,138.00 | 28,166,584.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 831,576,448.54 | 823,484,226.17 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 204,538,623.55 | 214,757,468.41 |
| 210302 | Түлш, халаалт | 489,635,393.20 | 433,875,442.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 137,402,431.79 | 174,851,315.76 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 249,839,617.25 | 140,094,348.72 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,295,049.00 | 4,743,830.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 64,362,950.00 | 42,965,896.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,953,292.51 | 11,740,773.88 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал |  | 830,350.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,445,000.00 | 8,507,656.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 121,117,198.40 | 63,383,502.74 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 32,666,127.34 | 7,922,339.10 |
| **2105** | **Нормативт зардал** | 563,786,623.95 | 486,662,087.92 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,223,563.85 | 1,771,800.00 |
| 210501 | Хоол | 545,762,560.10 | 444,453,647.92 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 16,800,500.00 | 40,436,640.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 83,936,973.77 | 182,158,633.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 10,305,800.00 | 1,817,800.00 |
| 210602 | Тавилга | 1,999,900.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгаалдын хэрэгсэл | 6,105,000.00 | 5,781,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 65,526,273.77 | 174,559,233.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 18,921,165.00 | 70,115,379.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,947,000.00 | 38,892,767.00 |
| 210802 | Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 3,800,000.00 | 2,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 1,152,786.00 | 1,124,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 844,179.00 | 1,266,312.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 302,500.00 | 352,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,874,700.00 | 26,479,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 764,519,959.94 | 588,771,634.63 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 23,431,314.00 | 29,210,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 741,088,645.94 | 559,560,934.63 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 105,209,173.86 | 95,080,060.51 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 94,904,926.00 | 83,389,072.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 86,724,926.00 | 73,589,072.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,180,000.00 | 9,800,000.00 |
| **2134** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт шилжүүлэг** | 10,304,247.86 | 11,690,988.51 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,304,247.86 | 11,663,488.51 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 27,500.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(480,746,791.60)** | **(344,653,079.76)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(480,746,791.60)** | **(344,653,079.76)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ төгрөгөөр /*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,201,162,456.84 | 11,607,248,766.06 | (2,944,537,009.81) | 14,863,874,213.09 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,201,162,456.84 | 11,607,248,766.06 | (2,944,537,009.81) | 14,863,874,213.09 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (480,746,791.60) | (480,746,791.60) |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,201,162,456.84 | 11,607,248,766.06 | (3,425,283,801.41) | 14,383,127,421.49 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 6,201,162,456.84 | 11,607,248,766.06 | (3,425,283,801.41) | 14,383,127,421.49 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 6,420,100.00 | | | 6,420,100.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (344,653,079.76) | (344,653,079.76) |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 6,207,582,556.84 | 11,607,248,766.06 | (3,769,936,881.17) | 14,044,894,441.73 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ төгрөгөөр /*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **3,897,394,582.50** | **3,780,473,016.63** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,461,248,882.50** | **1,406,041,616.63** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,461,248,8821.50 | 1,406,041,616.63 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,461,248,882.50 | 1,406,041,616.63 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,303,883,112.00 | 1,1560,329,149.63 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 143,915,943.27 | 255,712,467.00 |
| 140004 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 13,449,827.23 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,436,145,700.00** | **2,374,431,400.00** |
| **1311** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,436,145,700.00 | 2,349,181,220.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,436,145,700.00 | 2,349,181,220.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **25,250,000.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 25,250,000.00 |
| **2** | **ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,891,299,682.50** | **3,757,901,326.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,891,299,682.50** | **3,757,901,326.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,786,770,508.64** | **3,662,821,266.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,540,059,576.72 | 1,579,257,281.49 |
| 210101 | Үндсэн цалин | 1,052,578,473.81 | 913,946,314.68 |
| 210102 | Нэмэгдэл | 374,499,360.11 | 516,104,284.20 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 112,981,742.80 | 144,234,182.61 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 4,972,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 209,873,446.43 | 202,456,509.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 132,579,725.43 | 143,185,689.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,521,626.00 | 15,869,531.37 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,212,600.00 | 12,453,704.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,528,095.00 | 2,780,998.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 38,031,400.00 | 28,166,584.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 796,026,417.34 | 974,383,254.17 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 221,538,623.55 | 214,757,468.41 |
| 21002 | Түлш, халаалт | 437,085,362.00 | 584,774,470.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 137,402,431.79 | 174,851,315.76 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 244,356,400.53 | 125,747,711.08 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,745,320.00 | 7,739,058.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 97,878,950.00 | 44,791,047.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 13,371,892.51 | 11,740,773.88 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,159,800.00 | 830,350.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 10,945,000.00 | 8,507,656.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 108,255,438.02 | 52,138,826.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 816,256,279.85 | 464,029,436.30 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,799,942.85 | 1,183,592.00 |
| 210502 | Хоол хүнс | 767,435,837.00 | 408,254,544.30 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 47,020,500.00 | 54,591,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 121,993,122.77 | 163,279,266.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 11,105,500.00 | 1,817,800.00 |
| 210602 | Тавилга | 1,999,900.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 6,105,000.00 | 5,781,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 102,782,722.77 | 155,679,866.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 37,789,765.00 | 124,457,108.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,564,000.00 | 93,234,496.00 |
| 210802 | Аудит,баталгаажуулалт | 7,600,000.00 | 2,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,152,786.00 | 1,124,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 84,179.00 | 1,266,312.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 302,500.00 | 352,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,326,300.00 | 26,479,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,415,500.00 | 29,210,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,415,500.00 | 29,210,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **94,224,926.00** | **95,080,060.51** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 94,224,926.00 | 83,389,072.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 86,724,926.00 | 73,589,072.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,500,000.00 | 9,800,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 11,690,988.51 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,304,247.86 | 11,663,488.51 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 27,500.00 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,94,900.00** | **22,571,690.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГО** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ** | **6,094,900.00** | **22,571,690.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,094,900.00** | **22,571,690.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,094,900.00 | 22,571,690.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 6,094,900.00 | 22,571,690.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(6,094,900.00)** | **(22,571,690.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ мянган төгрөг /*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 6,228,079,400.00 | 3,743,559,528.10 | 2,484,519,871.90 | 60.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 6,228,079,400.00 | 3,743,559,528.10 | 2,484,519,871.90 | 60.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,144,187,000.00 | 3,660,170,456.10 | 2,484,016,543.90 | 59.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,935,031,100.00 | 1,574,284,781.49 | 1,360,746,318.51 | 53.6 |
| 210101 | Үндсэн цалин | 1,957,111,000.00 | 913,946,314.68 | 1,043,164,685.32 | 46.7 |
| 210102 | Нэмэгдэл | 797,340,200.00 | 516,104,284.20 | 281,235,915.80 | 64.7 |
| 210106 | Унаа болон бусад нөхөн олговор | 180,579,900.00 | 144,234,182.61 | 36,345,717.39 | 79.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 390,260,500.00 | 202,456,509.08 | 187,803,990.92 | 51.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 308,427,400.00 | 143,185,689.98 | 165,241,710.02 | 46.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 20,458,300.00 | 15,869,531.37 | 4,588,768.63 | 77.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,366,600.00 | 12,453,704.73 | 3,912,895.27 | 76.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,091,700.00 | 2,780,998.38 | 1,310,701.62 | 68.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 40,916,500.00 | 28,166,584.62 | 12,749,915.38 | 68.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,052,206,100.00 | 974,383,254.17 | 77,822,845.83 | 92.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 280,450,000.00 | 214,757,468.41 | 65,692,531.59 | 76.6 |
| 210302 | Түлш, халаалт | 532,160,600.00 | 584,774,470.00 | (52,613,870.00) | 109.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 239,595,500.00 | 174,851,315.76 | 64,744,184.24 | 73.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 219,112,200.00 | 129,555,651.08 | 89,556,548.92 | 59.1 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,617,800.00 | 7,739,058.00 | 3,878,742.00 | 66.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 94,982,400.00 | 44,791,047.00 | 50,191,353.00 | 47.2 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,587,100.00 | 11,740,773.88 | (153,673.88) | 101.3 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,252,000.00 | 830,350.00 | 421,650.00 | 66.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 8,000,000.00 | 8,507,656.20 | (507,656.20) | 106.3 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 91,672,900.00 | 55,946,766.00 | 35,726,134.00 | 61.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,062,809,600.00 | 464,029,436.30 | 598,780,163.70 | 43.7 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,560,000.00 | 1,183,592.00 | 376,408.00 | 75.9 |
| 210502 | Хоол, хүнс | 989,141,400.00 | 408,254,544.30 | 580,886,855.70 | 41.3 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 72,108,200.00 | 54,591,300.00 | 17,516,900.00 | 75.7 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 217,667,400.00 | 171,061,466.00 | 46,605,934.00 | 78.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,644,400.00 | 9,600,000.00 | 44,400.00 | 99.5 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,687,500.00 | 5,781,600.00 | 1,905,900.00 | 75.2 |
| 210604 | Урсгал засвар | 200,335,500.00 | 155,679,866.00 | 44,655,634.00 | 77.7 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 222,969,900.00 | 110,207,108.00 | 112,762,792.00 | 49.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 203,139,900.00 | 91,134,496.00 | 112,005,404.00 | 44.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,500,000.00 | 1,124,500.00 | 375,500.00 | 75.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,500,000.00 | 1,266,312.00 | 233,688.00 | 84.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 500,000.00 | 352,000.00 | 148,000.00 | 70.4 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,330,000.00 | 14,329,800.00 | 200 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,130,200.00 | 34,192,250.00 | 9,937,950.00 | 77.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 44,130,200.00 | 34,192,250.00 | 9,937,950.00 | 77.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 83,892,400.00 | 83,389,072.00 | 503,328.00 | 99.4 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 83,892,400.00 | 83,389,072.00 | 503,328.00 | 99.4 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 74,092,400.00 | 73,589,072.00 | 503,328.00 | 99.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,800,000.00 | 9,800,000.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,228,079,400.00 | 3,743,661,507.12 | 2,484,417,892.88 | 60.1 |
| **1320** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,349,181,400.00 | 2,337,619,890.49 | 11,561,509.51 | 99.5 |
| 132001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,349,181,400.00 | 2,337,619,890.49 | 11,561,509.51 | 99.5 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 3,878,898,000.00 | 1,406,041,616.63 | 2,472,856,383.37 | 36.2 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,755,502,900.00 | 1,150,329,149.63 | 2,605,173,750.37 | 30.6 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 123,395,100.00 | 255,712,467.00 | (132,317,367.00) | 207.2 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | | - | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - | - | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 158 | 142 | 16 | 89.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 99 | 90 | 9 | 90.9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 58 | 51 | 7 | 87.9 |

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/ төгрөгөөр /*

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **25,250,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **25,250,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 25,222,500.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 4,972,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 4,972,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 6,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 6,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 14,250,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 2,100,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 12,150,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **27,500.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 27,500.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хөрөнгийн хөдөлгөөнийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж байх тухай, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2021 оны 11 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Бэст фортуна аудит ХХК-ийн аудитор Н.Эрдэнэбат, аудитор Ч.Дуламсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг захирал Ж.Оюунцэцэг хэрэгжүүлсэн.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бэст фортуна аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Улс үндэстний хүүхэд, өсвөр залуу үеийг нийгмийн харилцааны үнэт баялаг, үндэстний ёс заншлаас суралцуулах, хүүхдийн эрхэд суурилсан хөгжлийг дэмжих, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх, чанартай хүрээмжтэй үйлчилгээг үзүүлэх хөгжлийн хөтөлбөрийн арга зүйг дэлгэрүүлэх” үйл ажиллагаа явуулахад оршино.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь Хүүхэд бүрийг нийгмийн амьдралд оролцогч, санаачлагатай, бүтээлч, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх, харилцааны ур чадвар, соёлд суралцахад дэмжлэг үзүүлэх, уламжлалт зан заншил, улс үндэстнүүдийн соёлыг танин мэдэх, амьдрах ухааны чадвар, дадал суулгах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилтан тайлант онд 10 чиглэлээр, 29 ажил хийхээр төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнасан боловч хяналт шалгалт хийх удирдамж гараагүй, зөвлөмж өгөөгүй, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дотоод хяналтын газрын байцаагч нартай хамтран

байгууллагын үйл ажиллагаанд хяналт хийсэн байна. Дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний ажилтан санхүү бүртгэлийн

мэргэжилтэй боловч хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой бие даасан хяналт хийгээгүй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын ажилтны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр бэлтгэж ирүүлсэн боловч доорх зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Нэмэлт санхүүжилт, түүний зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэн гаргасан;
- Төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнасан байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 4,426,113.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 44,261.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 464,834.0 мянган төгрөгөөр буюу 3,2 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 171,614.4 | 121,751.2 | (49,863.2) |
| Урьдчилгаа | 27,000.0 | 27,000.0 | - |

| | | | |
|---|---|---|---|
| Бараа материал | 727,153.2 | 734,549.9 | 7,396.7 |
| Үндсэн хөрөнгө | 13,784,588.5 | 13,362,220.9 | (422,367.6) |
| **Нийт хөрөнгө** | **14,710,356.1** | **14,245,522.1** | **(464,834.0)** |
| Өр төлбөр | 327,228.7 | 200,627.6 | (126,601.1) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 14,383,127.4 | 14,044,894.4 | (338,233.0) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **14,710,356.1** | **14,245,522.1** | **(464,834.0)** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага данс 49,863.7 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагчидтай холбогдсон авлага 946.0 мянга, байрны түрээсийн авлага 32,987.2 мянга, төлбөртэй үйлчилгээний авлага 17,219.8 мянга, тээвэр шатахууны авлага 2,075.0 мянган төгрөгөөр тус тус буурснаас голлон шалтгаалсан.
- Бараа материалын данс 275 хүүхдийн зөөлөн эдлэл 12 дугаар сард худалдан авснаас шалтгаалж 7,396.7 мянган төгрөгөөр өссөн.
- Үндсэн хөрөнгө данс тайлант онд ХНХЯ-ны хөрөнгө оруулалтаар төв байрны дээврийн засварт 108,205.1 мянган төгрөг, Швейцарийн хөгжлийн агентлаг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын төслөөс тоног төхөөрөмж, тавилга 12,763.5 мянган төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдсэн, хуримтлагдсан элэгдэл 559,560.9 мянган төгрөг, 6,951.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан зэргээс шалтгаалж 422,367.6 мянган төгрөгөөр буурсан.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвөөс 1,847,718.5 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогыг 3,878,898.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 5,557,729.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал засвар, дотоод албан томилолт, тавилга эд хогшлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хасч 498,537.1 мянган төгрөгөөр бууруулж төсвийн санхүүжилтийг 1,349,181.4 мянган төгрөгөөр баталсан.

Төсвийн тодотголоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,025,250.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 6,253,329.4 мянган төгрөгөөр баталсан.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 6,228,079.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,349,181.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,878,898.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,349,181.4 мянга, өөрийн орлогоор 1,406,041.6 мянга, нийт 3,755,223.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,743,559.5 мянган төгрөгийг зарцуулж 11,663.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 2,472,856.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс буурсан нь амрагч хүүхэд аваагүйгээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,743,559.5 мянган төгрөг буюу 60.1 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 386,436.1 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 214,404.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсанаас голлон шалтгаалсан байна.

*Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/

| Д/Д | Хөтөлбөр, арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 72207 | Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр | 6,228,079.4 | 3,743,559.5 | (2,484,519.8) | 60.1 |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны урсгал зардал | 6,144,187.0 | 3,660,170.5 | (2,484,016.5) | 59.6 |
| 1.2 | 80802 | Тэтгэмж, урамшуулал | 83,892.4 | 83,389.1 | (503.3) | 99.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Швейцарийн хөгжлийн агентлагаас мөнгөн хараацай урлагийн цахим наадамд зориулж 25,250.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 14,250.0 мянга, багаж техник хэрэгсэл худалдан авахад 6,000.0 мянга, бусад зардалд 4,972.5 мянган төгрөг тус тус зарцуулж, үлдэгдэл 27.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

<u>Асуудлыг онцолсон хэсэг:</u>

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгаанд Соёлын өвийн үндэсний төвөөс балансаас балансад 2020 онд шилжин ирсэн 85,000.0 мянган төгрөгийн үнэтэй, хуучин Паз автобусны ашиглалтын зардал өндөр тул ашиглаагүй байна.

2. Нийслэлийн Засаг даргын шийдвэр, өмнөх аудитын албан шаардлагын дагуу байгууллага, хувь хүмүүстэй маргаантай байсан 545.0 мянган м2 газрыг буцаан авч газар эзэмших гэрчилгээг шинэчлүүлэн, санхүүгийн тайланд тусгасан.

<u>Бусад асуудлын хэсэг:</u>

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 60.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Нүүрсний чанар муугаас (илчлэг 3600 ккал байхаас 2800 ккал-тай нийлүүлдэг) уурын 1 зуух илүү ажиллаж нүүрсний болон цахилгааны зардал хэтэрч байгааг цаашид анхаарах үйл явдал гэж үзсэн болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь 206 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 181 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 23 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансны тухай хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын үнэлгээ хийсэн тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн А-3 сертификат байхгүй, үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг болон ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 39,854.8 мянган төгрөгийн 10 зөрчил илэрснээс аудитын явцад 3 зөрчлийг залруулж, шилэн дансны 2 мэдээллийг нөхөн оруулсан байна.

Өмнөх жилийн эцсийн аудитаар тогтоосон төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 44,571.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагын хэрэгжилт 32.1 хувь, 27,462.0 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 10 хувьтай байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

*/мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 7,734.0 | 1 | 7,734.0 | - | - | 100.0 |
| Албан шаардлага | 4 | 44,571.0 | 3 | 14,309.0 | 1 | -30,262.0 | 75.0 |
| Зөвлөмж | 5 | 27,462.0 | 4 | 462.0 | 1 | -27,000.0 | 80.0 |
| Нийт дүн | 7 | 79,777.0 | | 22,505.0 | | -57,262.0 | 85.0 |

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмж, шүүхэд нэхэмжлэл гаргасан 30,262.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Авлага барагдуулах ажлын гүйцэтгэлийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 56,287.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.941.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 944.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 8,299.3 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 10,102.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд  зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 19,346.0 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 24,915.1 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1. Залруулсан алдаа
Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой доорх алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан нэмэлт санхүүжилтийн 25,250.0 мянган төгрөгийг залруулж нэмэлт санхүүжилтийн тайлан гаргуулсан.
- Улсын төсвийн санхүүжилтаас төвлөрүүлсэн 11,663.5 мянга, нэмэлт санхүүжилтаас төвлөрүүлсэн 27.5 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайланд тус тус залруулсан.

### 4.2. Төлбөрийн акт

1. Дулааны цехээс ахмад настны тэтгэвэрт гарсан 2 ажилтанд 782.1 мянган төгрөгийн 7 өдрийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төлбөрийн акт тогтоов.

2.Гэрээт ажилтанд олгосон цалингаас 162.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг дутуу суутгасан байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 “үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 25 дугаар зүйлийн 25.1.1. “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1 заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, 25.1.2. “энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан орлогын дүнд”, энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### 4.3. Албан шаардлага

1. Авлага, урьдчилж төлсөн тооцооны дансанд 13 байгууллага, хувь хүнээс авах, 2-аас дээш жилийн насжилттай 74,640.4 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй, 11 байгууллагад 94,549.3 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.”Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” *гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-д заасан 1 удаагийн гүйлгээний дээд хязгаарыг зөрчиж 12 байгууллага, хувь хүнд жижиг мөнгөн сангаас нийт 7,363,428 төгрөгийн бэлэн мөнгө олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 хавсралт "Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам" энэ журмын 6.3 “Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300.000 төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500.000 төгрөгөөс хэтрэхгүй байна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, мөн санхүүгийн тайлангийн “үнэн зөв”, “тохиолдсон байх”, батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

3. Ажилчдад олгосон нэмэгдэл цалингаас НДШ суутгаагүй, ХХОАТ алдаатай суутгаснаас 935,881.00 төгрөг илүү олгосон байна.
Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

*Кассын баримтыг шалгахад 2021 оны 1, 2 дугаар сард худалдан авалтанд 17 иргэнээр 65.3 мянган төгрөгийн и-баримт авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна*

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

*Худалдан авалтад байгууллагын нэр дээр НӨАТ-ын баримт авч байх*

2.Удирдлагын хяналттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

*Ерөнхий захирлын 70 ширхэг "Б" тушаал, 1 ширхэг "А" тушаалын үндэслэл дээрх хуулийн заалт буруу бичигдсэн, 4 дүгээр сард 7 хүний тушаалыг алдаатай гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна*

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

*Тушаал боловсруулахдаа хуулийн заалт болон үндэслэлийг нягталж, ажилд томилсон болон албан тушаал өөрчилсөн хугацааг үнэн зөв гаргаж байх*

3.Дотоод хяналттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

*Байгууллагын 2021 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор 3 дансанд 8,898.9 мянган төгрөгийн эд хөрөнгө дутуу тоологдсон, шатахууны талоныг сар бүр тоолоогүй, хагас жилээр тоолсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ заавал хийх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна*

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

*Тушаалаар томилогдсон комисс эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолж илтгэх хуудас, нягтлан бодогч тооцоо бодож үр дүнг удирдлагад тус тус танилцуулж байх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | Төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан нэмэлт санхүүжилтийн 25,250.0 мянган төгрөгийг залруулж нэмэлт санхүүжилтийн тайлан гаргуулсан. | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 25,250.0 | 1 | 25,250.0 | | | | | | | | |
| 2 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | Улсын төсвийн санхүүжилтаас төвлөрүүлсэн 11,663.5 мянга, нэмэлт санхүүжилтаас төвлөрүүлсэн 27.5 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэл, нэмэлт санхүүжилтийн тайланд тус тус залруулсан. | Зөрчлийг давтахгүй байх | 2 | 11,691.0 | 2 | 11,691.0 | | | | | | | | |
| 4 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | Дулааны цехээс 12 дугаар сарын 15-нд ахмад настны тэтгэвэрт гарсан А.Бямбарэнчин, Б.Содномдорж нарт 7 өдрийн цалин 782.1 мянган төгрөг илүү олгосон | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 782.1 | | | 1 | 782.1 | | | | | | |
| 5 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | Давхар ажилтай гэрээт ажилтан Алтанцогт олгосон цалингаас 162.0 мянган төгрөгийн ХХОАТ дутуу суутгасан | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 162.0 | | | 1 | 162.0 | | | | | | |
| 6 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | Захирлын А/80 дугаар тушаалаар олгосон нэмэгдэл цалингаас НДШ суутгаагүй, ХХОАТатвар алдаатай суутгаснаас үүссэн нийт 935.9 мянган төгрөгийн цалин илүү олгосон | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 935.9 | | | | | 1 | 935.9 | | | | |
| 7 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | 12 байгууллага, хувь хүнд жижиг мөнгөн сангаас 7,363.4 мянган төгрөгийн өндөр дүнтэй гүйлгээ хийсэн | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 7,363.4 | | | | | 1 | 7,363.4 | | | | |
| 8 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШЗ | Авлага, урьдчилж төлсөн тооцооны дансанд 13 байгууллага, хувь хүнээс авах, 2-аас дээш жилийн насжилттай 74,640.4 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй, 11 байгууллагад | Зөрчлийг давтахгүй байх | 1 | - | | | | | 1 | - | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 94,549.3 мянган төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн байна. | | | | | | | | | | | | | |
| 9 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШ3 | Кассын баримтыг шалгахад 2021 оны 1, 2 дугаар сард худалдан авалтанд 17 иргэнээр сугалааны дугаартай 65.3 мянган төгрөгийн и-баримт авсан | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 65.3 | | | | | | | | | 1 | 65.3 |
| 10 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШ3 | Цогцолборын ерөнхий захирлын 70 ширхэг "Б" тушаал, 1 ширхэг "А" тушаалын үндэслэл дээрх хуулийн заалт буруу бичигдсэн, 2021 оны 4 дүгээр сард 22 хоног ажилласан 7 хүний тушаалыг 4 дүгээр сарын 8-наас гэж 1,138.4 мянган төгрөгийн алдаатай гаргасан | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 1,138.4 | | | | | | | | | 1 | 1,138.4 |
| 11 | ОУХНЦ | АХГ-2022/237/НА-СТА-ТШ3 | Байгууллагын 2021 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор 3 дансанд 8,898.9 мянган төгрөгийн эд хөрөнгө дутуу тоологдсон | Зөрчлийг давтахгүй байх | 1 | 8,898.9 | | | | | | | | | 1 | 8,898.9 |
| Дүн | | | | | 11 | 56,287.0 | 2 | 36,941.0 | 2 | 944.1 | 3 | 8,299.3 | - | - | 3 | 10,102.6 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | - | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | | | | | 11 | 56,287.0 | 2 | 36,941.0 | 2 | 944.1 | 3 | 8,299.3 | - | - | 3 | 10,102.6 |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 59/A0150058 Улаанбаатар хот
АХГ-2022/237/НА-СТЗ-ТНЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дулааны цехээс ахмад настны тэтгэвэрт гарсан нэр бүхий 2 ажилтанд 782,123.00 төгрөгийн 7 өдрийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 782,123.00 /долоон зуун наян хоёр мянга нэг зуун хорин гурав/ төгрөгийг нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонбат, Ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-61.Docx

001090193

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 60/А0150058 Улаанбаатар хот

АХГ- 2022/237/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь 1 ажилтанд олгосон 8,224,956.00 төгрөгийн цалингаас 162,000.00 төгрөгийн ХХОАТ дутуу суутган тооцсон байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 25 дугаар зүйлийн 25.1.1. "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1 заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", 25.1.2. "энэ хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.4-т заасан орлогын дүнд", энэ хуулийн 21.2.4-т заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтнуудаас дутуу суутгасан ХХОАТ-ын 162,000.00 /нэг зуун жаран хоёр мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонбат, ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ж.ОЮУНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-60.Docx

001090191

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 313/А01500058 Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилчдад олгосон нэмэгдэл цалингаас НДШ суутгаагүй, ХХОАТ алдаатай суутгаснаас 935,881.00 төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. НДШ, ХХОАТ-ыг дахин тооцоолж, зөрчлийг залруулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонбат, Ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-320.Docx

0010800927

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

________ оны ____ дугаар сарын ____ № 314/А0150058 Улаанбаатар хот

АХГ-

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам"-д заасан 1 удаагийн гүйлгээний дээд хязгаарыг зөрчиж 12 байгууллага, хувь хүнд жижиг мөнгөн сангаас нийт 7,363,428 төгрөгийн бэлэн мөнгө олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 1 хавсралт "Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам" энэ журмын 6.3 "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300.000 төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500.000 төгрөгөөс хэтрэхгүй байна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, мөн санхүүгийн тайлангийн "үнэн зөв", "тохиолдсон байх", батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонбат, Ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ
БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНЦЭЦЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-319.Docx

0010800925

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 315/АО/50058 Улаанбаатар хот

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлага болон урьдчилж төлсөн тооцооны 2 жилээс дээш жилийн насжилттай 13 байгууллага, хувь хүнээс авах 74,640,400.00 төгрөгийн авлага барагдуулаагүй, 11 байгууллагад 94,549,300.00 төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" *гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захирганы хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийг барагдуулах ажлыг зохион байгуулах, дотоод хяналтыг сайжруулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Отгонбат, Ерөнхий нягтлан бодогч М.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.СЭРЖМЯДАГ |
| БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Ж.ОЮУНЦЭЦЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-318 Docx

0010800923

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ